



**МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/384

Ховд

**Улсын комисс байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Ховд аймгийн Жаргалант сумын Магсаржав багт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар "Сац гурван хайрхан" ХХК-ийн гүйцэтгэсэн 15 айлын орон сууцны барилга угсралтын ажлыг ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга: З.Өмиртай - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга

Гишүүд: Б.Эрдэнэцэцэг - Мэргэжлийн хяналтын газрын эрүүл ахуйн халдвар хамгаалалын хяналтын улсын байцаагч

З.Батзаяа - Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч

А.Оюунжаргал - Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч

Г.Амармэнд - "Мэдээлэл холбооны сүлжээ" төрийн өмчит компанийн Ховд аймаг дахь газрын ерөнхий инженер

М.Нансалмаа - Нийтийн аж ахуйн "Шим-Ус" орон нутгийн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ерөнхий инженер

Н.Ням-Эрдэнэ - "Ховд цахилгаан түгээх сүлжээ" ХХК-ийн ерөнхий инженер

8400 01 1925

Т.Бямбатемөр - "Ховд дулаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн ерөнхий инженер


С.Батдорж - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга

Ш.Мөнхзаяа - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн гэрээт ажилтан

Л.Ууганбаяр - "Сац гурван хайрхан" ХХК-ийн захирал

Нарийн бичгийн дарга: Б.Жамбалдорж - Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Тус 15 айлын орон сууцны барилга угсралтын ажлыг зураг, төслийн дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргахыг комиссын дарга (З.Өмиртай)-д үүрэг болгосугай.

 Б. ДҮГЭРЖАВ